



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 26

Эрдэнэт

Ээлжит хуралдаан зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн Ээлжит VI хуралдааныг 2017 оны 03 дугаар сарын 31-ны өдөр Эрдэнэт хотод зарлан хуралдуулж, дараах асуудал хэлэлцүүлэхээр тогтоосугай.

1.1.Боловсролын салбарыг 2014-2016 онд хөгжүүлэх хөтөлбөрийн биелэлт, цаашид боловсролын салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай.

1.2.“Багш” дэд хөтөлбөр батлах тухай.

1.3.Аймгийн нийгмийн эрүүл мэндийг сайжруулах 2014-2016 онд баримтлах бодлогын биелэлт, цаашид аймгийн эрүүл мэндийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай.

1.4.“Эмч” дэд хөтөлбөр батлах тухай.

1.5.Бусад.

Хоёр.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит VI хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтын ёсоор баталсугай.

Гурав.Хуралдааны бэлтгэл хангаж хуралдуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга П.Пүрэвлхагвад даалгасугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА